

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 14 дүгээр хавсралт*

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТӨЛБӨРТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТӨЛБӨРИЙН
ХЭМЖЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТӨЛБӨРТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, хураамжийн хэмжээг тогтоох үндэслэл, баримтлах зарчмыг тодорхойлоход оршино.

1.2. Тус журам нь иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон нисэх буудал, агаарын навигаци, бусад үйлчилгээг авч буй хэрэглэгчдэд хамаарна.

1.3. Агаарын хөлгөөр зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээний төлбөр хураамжийг энэ журмаар зохицуулахгүй.

1.4. Иргэний нисэхийн үйлчилгээний хураамжийг зохицуулалттай болон зохицуулалтгүй гэж ангилна.

1.5. Агаарын навигацийн болон нисэх буудлын үйлчилгээний хураамжийг тухайн үзүүлсэн үйлчилгээнд тооцно.

1.5.1. Үйлчилгээ үзүүлэгч нь агаарын навигацийн болон нисэх буудлын үйлчилгээний хураамжийг тогтоох, хэрэгжүүлэхэд Өрсөлдөөний тухай хуулийг баримтална.

1.5.2. Монгол Улсын холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байх;

1.6. Үйлчилгээний хураамжийг тогтооход дараах зарчмыг баримтална:

1.6.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ОУИНБ/-ын баримт бичигт заасан зарчмуудад нийцсэн байх;

1.6.2. Үйлчилгээний өртөг, зардалд суурилсан байх;

1.6.3. Үндэсний эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үйлчилгээний хураамжийн хэмжээг ялгавартай тогтоож болох бөгөөд ялгавартай тогтоох болсон зорилго, үндэслэлийг хэрэглэгчдэд ил тод тайлбарласан байна.

1.6.4. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үйлчилгээний зардлыг нөхөхөд үндэслэсэн байх;

1.6.5. Хураамжийн бүтэц нь хэрэглэгчдэд ойлгомжтой, ил тод, нээлттэй байх;

1.6.6. Хураамжийн тогтвортой байдлыг хангах;

Хоёр. Зохицуулалттай үйлчилгээний төлбөр хураамжийн төрөл

Үйлчилгээ үзүүлэгч нь энэ бүлэгт заасан үйлчилгээний үнэ тарифын хэмжээг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, мөрдөнө.

2.1. Агаарын навигацийн цогц үйлчилгээ нь дараах үйлчилгээнээс бүрдэнэ:

2.1.1. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ:

2.1.1.1. Бүсийн нислэгийн;

2.1.1.2. Ойртолтын;

2.1.1.3. Аэродромын нислэгийн;

2.1.1.4. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ (FIS);

2.1.1.5. Аюул түгшүүрийн мэдээллийн хангалт;

2.1.1.6. Нислэгийн хөдөлгөөний урсгалын зохицуулалт;

2.1.1.7. Агаарын зайн зохион байгуулалт /ASM/ (агаарын зайн ашиглалтын төлөвлөлт, зохицуулалт);

2.1.2. Холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн хангалтын үйлчилгээ:

2.1.2.1. Суурин болон хөдөлгөөнт холбоо;

2.1.2.2. Газрын болон сансрын навигацийн систем; болон

2.1.2.3. Хоёрдогч ажиглалтын радиолокатор /SSR/ болон хамааралтай ажиглалтын систем /ADS-B/-ийн;

2.1.2.4. Аэродромын гэрэл суултын систем;

2.1.3. Нисэхийн цаг уурын мэдээллийн үйлчилгээ:

2.1.3.1. Нислэгийн цаг агаарын бодит мэдээ /METAR, SPECI/;

2.1.3.2. Нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээ;

2.1.3.3. Буудал орчмын /TAF/;

2.1.3.4. Нислэгт аюултай цаг агаарын /SIGMET/;

2.1.3.5. Өндрийн салхины;

2.1.3.6. Чиглэлийн;

2.1.3.7. Бүс нутгийн;

2.1.4. Эрэн хайх, авран туслах үйлчилгээ:

2.1.4.1. Эрэн хайх, авран туслах ажиллагааны үед аюул түгшүүрийн мэдэгдэл ба нислэгийн зохицуулалт хийх;

2.1.4.2. Эрэн хайх, авран туслах агаарын хөлөг болон нисэх багийн үүрэгт ажлыг зохицуулах;

2.1.5. Нисэхийн мэдээллийн үйлчилгээ:

2.1.5.1. Нисэх багт агаарын навигацийн шуурхай мэдээлэл (NOTAM);

2.1.5.2. Нисэхийн мэдээллийн эмхэтгэл;

2.1.5.3. Нислэгийн зураг;

2.1.5.4. Нисэхийн мэдээллийн өгөгдлийн сан;

2.1.5.5. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ /Pre-flight information/;

2.1.5.5.1. аэродромын нислэгийн хөдөлгөөнтэй холбогдолтой мэдээ /нислэгийн төлөвлөгөө болон өөрчлөлтийн мэдээ/

2.1.6. Шалгалтын нислэгийн үйлчилгээ:

2.1.6.1. Холбоо, навигаци ажиглалтын тоног төхөөрөмжийн шалгалтын нислэг;

2.1.6.2. Хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр шалгах;

2.1.7. Нислэгийн журам зохиох үйлчилгээ:

2.1.7.1. Ил харааны нислэгийн журам;

2.1.7.2. Навигаци ашигласан хэрэглэлийн нислэгийн журам;

2.1.7.3. Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN) ашигласан хэрэглэлийн нислэгийн журам;

2.1.7.4. Нисдэг тэрэгний хэрэглэлийн нислэгийн журам.

2.2. Нисэх буудлын төлбөртэй үйлчилгээнд дараах үйлчилгээ багтана:

2.2.1. Буулт-хөөрөлтийн үйлчилгээ:

2.2.1.1. Буулт хөөрөлтийн зурвас, явгалах замын бэлэн байдлыг хангах;

2.2.1.2. Авран туслах, гал унтраах үйлчилгээний;

2.2.1.3. Шувуу, зэрлэг амьтны нөлөөллөөс сэргийлэх ажиллагаа;

2.2.1.4. Агаарын хөлгийн зогсоол;

2.2.1.5. Аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ (саадын хяналт, агаарын хөлөг хөтлөх үйлчилгээ)

2.2.2. Зорчигч үйлчилгээ:

2.2.2.1. Нисэх буудлын гадна талбайн;

2.2.2.2. Хүлээлгийн танхимын;

2.2.2.3. Хяналтын талбайн;

2.2.2.4. Зарлан мэдээлэх;

2.2.2.5. Зорчигчдод зайлшгүй шаардлагатай бусад (эх нялхсын өрөө, эмнэлгийн үйлчилгээний цэг);

2.2.2.6. Хамгаалалтын;

2.2.3. Агаарын хөлгийн зогсоолын үйлчилгээ:

2.2.3.1. Агаарын хөлгийг зогсолтын талбайгаар хангах;

2.2.3.2. Перрон дээрх зогсолтын талбайн гэрэлтүүлэг

2.2.4. Агаарын хөлгийг нисэх буудалд холбох хүзүүвч (air bridge)-ийн үйлчилгээ;

2.2.5. Тээш дамжуулах системийн үйлчилгээ;

2.2.6. Ачаа шуудан (терминал)-ийн үйлчилгээ:

2.2.6.1. Энгийн ачааг тээвэрлэлтэд хүлээн авах (жинлэх, өргөх, буулгах, аюулгүй байдлын үзлэг);

2.2.6.2. Тусгай ачааг тээвэрлэлтэд хүлээн авах (аюултай ачаа, амьд амьтан, шарил, түргэн муудах болон тусгай арчилгаа шаардах бусад ачаа);

2.2.6.3. Тээвэрлэгдэж ирсэн ачааг хүлээн авах (Тээвэрлэгчээс терминалд хүлээн авах);

2.2.6.4. Тээвэрлэгдэж ирсэн ачааг олгох;

2.2.6.5. Хадгалалт (Гаалийн баталгаат болон түр агуулахад хадгалах);

2.2.6.6. Агаарын хөлөгт ачаа ачих, буулгах үйлчилгээ;

2.2.6.7. Ачаа өргөгч механизмын ашиглалтын үйлчилгээ;

2.2.6.8. Ачааны аюулгүй байдлын үзлэгийн үйлчилгээ.

2.2.7. Агаарын хөлгийн хамгаалалтын үйлчилгээ;

2.2.8. Аюулгүй байдлын үзлэгийн хяналт, шалгалтын үйлчилгээ.

Гурав. Хураамжийн зохицуулалтгүй үйлчилгээний төрөл

3.1. Энэ бүлэгт заасан үйлчилгээний үнэ тарифыг Үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, мөрдөх бөгөөд энэ талаарх мэдээллийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтмол хүргүүлнэ.

3.2. Журмын Бүлэг 2-т зааснаас бусад үйлчилгээг зохицуулалтгүй үйлчилгээний төрөлд хамааруулна.

3.2.1. Үүнд дараах үйлчилгээнүүд багтана:

3.2.1.1. Цахилгаан дамжуулах, түгээх;

3.2.1.2. Интернет, суурин холбоо;

3.2.1.3. Нийтийн тээвэр;

3.2.1.4. Нисэхийн сургалт;

3.2.1.5. Байр талбайн түрээс;

3.2.1.6. Зорчигч бүртгэлийн цэгийн үйлчилгээ дундын хэрэглээний системийн хамт /CUTE систем (Common User Terminal Equipment)/

3.2.1.7. Ачаа тээш хадгалах;

3.2.1.8. Сурталчилгааны самбарын түрээс;

3.2.1.9. Тусгай үйлчилгээний танхимын үйлчилгээ(гадаад, дотоодын хүндэт зочны танхим, бизнес танхим);

3.2.1.10. Нийтийн хоолны үйлчилгээ;

3.2.1.11. Автомашин зогсоолын үйлчилгээ;

3.2.1.12. Хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх олгох;

3.2.1.13. Шатахуун тээвэр;

3.2.1.14. Нисэх буудлын орчны талбай болон ойр зэрэгцээ орших газруудыг нийтийн хэрэглээний дэд бүтцээр хангах /цахилгаан, дулаан, цэвэр ус, ахуйн хэрэглээний ус, бохир ус цэвэршүүлэх, хог хаягдал г.м./

3.2.1.15. Бусад

3.2.1.14. Агаарын хөлгийн газрын тусгай үйлчилгээ:

3.2.1.14.1. Цахилгаан тэжээлийн тоног төхөөрөмж; агаарын хөлгийг цахилгаан тэжээлээр хангах төхөөрөмж;

3.2.1.14.2. Онгоц чирэгч трактор;

3.2.1.14.3. Цэвэр усны автомашин;

- 3.2.1.14.4. Бохир цэвэрлэгч автомашин;
- 3.2.1.14.5. Бохирыг цэвэрлэх төхөөрөмж;
- 3.2.1.14.6. Техник үйлчилгээний засварын автомашин;
- 3.2.1.14.7. Агааржуулагч төхөөрөмж;
- 3.2.1.14.8. Агаарын хөлгийг агаараар асаагч;
- 3.2.1.14.9. Шатахуун сумлагч автомашин;
- 3.2.1.14.10. Халаагч автомашин;
- 3.2.1.14.11. Агаарын хөлгийн мөстөлт арилгах тоног төхөөрөмж;
- 3.2.1.14.12. Зорчигчийн шат;
- 3.2.1.14.13. Зорчигч болон нисэх багийн гишүүдийг агаарын хөлөг рүү тээвэрлэх;
- 3.2.1.14.14. Зорчигчийн хүнс тээвэрлэх автомашин;
- 3.2.1.14.15. Ачаа тээшний туузан дамжуурга;
- 3.2.1.14.16. Контейнер ачиж буулгах төхөөрөмж;
- 3.2.1.14.17. Ачаа, тээшний трактор гэх мэт.

Дөрөв. Зохицуулалттай болон зохицуулалтгүй үйлчилгээний хураамжийг тогтоох

4.1. Үйлчилгээний хураамж тогтоох

4.1.1. Зохицуулалттай үйлчилгээний хураамж тогтоох, өөрчлөх саналыг хүлээж авснаас хойш ажлын 60 хоногийн дотор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан, зөвшөөрсөн эсэх тухай бичгээр мэдэгдэнэ.

4.1.2. Үйлчилгээ үзүүлэгч батлагдсан хураамжийг мөрдөж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө нисэхийн мэдээллийн эмхэтгэлд холбогдох журмын дагуу нийтлүүлсэн байна.

4.1.3. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж тогтоох

4.1.3.1. Агаарын хөлөгт агаарын навигацийн цогц үйлчилгээ үзүүлж, хураамжийг нэгдмэл байдлаар тогтооно.

4.1.3.2. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг нислэгийн маршрутын 100 километр тутамд, агаарын хөлгийн хөөрөлтийн дээд хүнд /MTOW/-ийг үндэслэн тогтооно.

4.1.4. Нисэх буудлын үйлчилгээний хураамж тогтоох

4.1.4.1. Энэ журмын 2.2.1-д заасан буулт-хөөрөлтийн үйлчилгээний хураамжийг агаарын хөлгийн хөөрөлтийн дээд хүндийн жин (MTOW)-г үндэслэн нэг тонн тутамд, олон улсын болон орон нутгийн нислэгийн чиглэлээр, нисэх буудлын аэродромын ангилал тус бүрээр тогтооно.

4.1.4.2. Энэ журмын 2.2.2-т заасан зорчигч үйлчилгээний хураамжийг олон улсын болон орон нутгийн чиглэлд ялгавартай тогтооно.

4.1.4.2.1. Зорчигч үйлчилгээний хураамжийг агаарын тээвэрлэгчийн тийзэнд багтаан авна;

4.1.4.3. Энэ журмын 2.2.3-т заасан агаарын хөлгийн зогсоолын хураамжийг дараах байдлаар тогтооно:

4.1.4.3.1. Агаарын хөлөг нисэх буудалд буулт хийснээс хойш перрон дээр зогссон эхний 2 цагт хураамж ногдуулахгүй;

4.1.4.3.2. Агаарын хөлгийн хөөрөлтийн хамгийн их жин (MTOW) болон илүү зогссон хугацааг үндэслэн цагаар тооцно;

4.1.4.3.3. Зогсолт хийсэн хугацааг агаарын хөлөг талбай дээр зогсолт хийж эхэлсэн цагаас, явгалах зам руу гарсан цаг хүртэлх нийт хугацаанаас 15 минут хасч тооцно.

4.1.4.4. Энэ журмын 2.2.4-т заасан Агаарын хөлгийг нисэх буудалд холбох хүзүүвч (air bridge)-ийн үйлчилгээний төлбөрийг агаарын хөлөг хүзүүвчинд холбогдсон цагийг үндэслэн тооцно.

4.1.4.5. Энэ журмын 2.2.5-д заасан зорчигчийн ачаа тээш дамжуулах систем, тоног төхөөрөмж ашиглуулсны үйлчилгээний төлбөрийг нислэг тутмаас тооцно.

4.1.4.6. Энэ журмын 2.2.6-д заасан ачаа шуудан (терминал)-ийн үйлчилгээний хураамжийг ачааны жин болон хадгалах хугацааг үндэслэн;

4.1.4.6.1. Агаарын хөлөгт ачаа ачих, буулгах ачигчийн үйлчилгээний төлбөрийг нэг/хүн цагаар тооцно;

4.1.4.6.2. Ачаа өргөгч механизмын ашиглалтын үйлчилгээний төлбөрийг ажилласан цагаар тооцно.

4.1.4.7. Энэ журмын 2.2.7-д заасан агаарын хөлгийн хамгаалалтын хураамжийг энгийн болон тусгай хамгаалалтын хувьд ялгавартай тогтоож, үйлчилгээний төлбөрийг агаарын хөлгийн хүндийн жин, хамгаалсан цагийг үндэслэн тооцно.

4.1.4.8. Энэ журмын 2.2.8-д заасан үйлчилгээг тооцохдоо зорчигч тутмаас тооцно.

Тав. Хөнгөлөлт, чөлөөлөлт, зохицуулалт

5.1 Хөнгөлөлт, чөлөөлөлт

5.1.1. Дараах төрлийн нислэгт агаарын навигацийн болон нисэх буудлын үйлчилгээний хураамжаас чөлөөлнө:

5.1.1.1. Эрэн хайх, авран туслах нислэг;

5.1.1.2. Агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн эсхүл ослын буулт;

5.1.1.3. Шалгалтын нислэг (Холбоо навигаци, гэрэл суултын тоног төхөөрөмж, агаарын хөлгийн болон нислэгийн журам зохиох гм.);

5.1.1.4. Засгийн газар хоорондын хэлэлцээрээр үйлчилгээний төлбөр хураамжаас чөлөөлөгдсөн нислэг.

5.2. Үйлчилгээ үзүүлэгч зах зээлийн хөгжүүлэх, маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлчилгээний төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.

5.3 Үйлчилгээний орлогын зарцуулалт

5.3.1. Үйлчилгээний орлогыг нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

Зургаа. Хяналт, шалгалт, хариуцлага

6.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага салбар дахь үйлчилгээний хураамжийн хэмжээнд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

6.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр, хураамж тогтоосон үндэслэл болон энэхүү журмын 1.6-д заасан зарчимд нийцсэн эсэхэд хянана.

6.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хянан шалгасан мэргэжилтэн шаардлагатай гэж үзвэл тухайн байгууллагын санхүүгийн болон тээвэрлэлтийн мэдээлэл бусад тайлан, гэрээ хэлцэл, мэдээллийг ирүүлэхийг үйлчилгээ үзүүлэгчээс шаардаж болно. Шаардсан мэдээг ажлын 5 хоногийн дотор гаргаж ирүүлнэ.

6.3. Шаардсан мэдээг 6.2-т заасан хугацаанд ирүүлээгүй бол Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь үйлчилгээний хураамжийг хянах үйл ажиллагааг түр түдгэлзүүлнэ.

6.4. Асуудал үүссэн тохиолдолд уг асуудлын зохистой шийдлийг олох, үйлчилгээний хураамжийн саналын талаар зөвлөмжийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөлөл, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл түүнчлэн ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүдийг оролцуулан зөвлөлдөн шийдвэрлэнэ.

6.5. Энэ журмыг зөрчсөн иргэн хуулийн этгээдэд Иргэний нисэхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

---oOo---